

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Боть XXXX (463)

2016

(16-24)

ЖЕНДЕРИЙН ХЭЛ ШИНЖЛЭЛ

Д. Баасанбат *

Жендерийн хэл шинжлэл гэдэг нь хүмүүсийн хүлээсэн үүрэг хариуцлага, тэдэнд учрах саад бэрхшээл, боломж бололцоог дүгнэн нягтлах, нийгэм эдийн засаг, улс төрийн шинжтэй хувьсах хэмжигдэхүүн, харилцааны онол бөгөөд эрэгтэй эмэгтэй хүмүүсийн аль алинд нь хамаарна.

Хүн судлаач Маргарет Мид жендер бол биологийн хувьд бус харин соёл иргэншлээр нөхцөлдөж, түүхэн үйл явцад бүрэлдсэн, соёлын харьцангуй шинж чанараар тодорхойлж болох зүйл (1.189) гэж тэмдэглэсэн байна.

Латин хэлний *genus* (хүйс, төрөл, зүйл) гэсэн утгыг заадаг, англи хэлний дүрмийн ангилал болох хүйс гэдэг үгтэй адил төстэй, юуны тухай өгүүлж байна гэдгээсээ хамаарч *sex role* буюу *хүйсийн үүрэг*, *sex difference* буюу *хүйсийн ялгаа* гэх мэт үгийг төлөөлнө. Өөрөөр хэлбэл, хүний биологийн хүйс (*natural gender*)-ийн талаар ярих тохиолдолд шинэ нэр томъёо эрж хайх хэрэгтэй гэсэн үг юм гэж А.В.Кирилина (2.20) тэмдэглэжээ.

М.В.Ласков (3) жендер гэдэг нь барууны социологиос зээлдсэн ойлголт бөгөөд ерөнхийдөө хүний биологийн хүйс, хүйсийн стереотип, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурь гэсэн гурван үндсэн шинж чанарын цогц юм гэж үзсэн байна.

Жендерийн үүрэг нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурь болон тэдэнд ноогддог үйл ажиллагааг илэрхийлнэ. Хүмүүсийн хүйс өөрчлөгддөггүй хэдий ч жендерийн үүрэг нь цаг хугацаа өнгөрөхөд шинэчлэгдэн өөрчлөгддөг.

Жендерийн үзэл баримтлалын үүсэл нь анх эмэгтэйчүүдийн нийгэм, улс төрийн эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой гарч ирсэн хөдөлгөөн юм. Жендерийн үзэл баримтлалын гол зорилго бол жендерийн тэгш байдлыг хангахад оршино.

XX зууны эхэн үеэс эмэгтэйчүүдийг дэмжсэн үзэл баримтлал хөгжиж эхэлсэн ажээ. Энэ үзэл онолыг баримтлагчдыг *феминизм* буюу *феминистүүд* гэдэг болжээ. Энэ чиглэл нь хөгжлийн явцдаа *феминологи* буюу *эмэгтэйчүүд судлал* болтлоо хөгжсөн байна. Эмэгтэйчүүд судлал нь аажмаар нийгэмшил ба соёлын бүхий л талыг юуны түрүүнд хүйсийн хэмжигдэхүүнээр задлан үзэх хандлагатай феминист үйл ажиллагаа эрчимтэй хөгжсөний үр дүнд жендер судлал (*gender study*) дэлгэрэн хөгжсөн байна. Одоо үед жендер судлал нь эрэгтэйчүүд судлалд “андрология” нөлөөлж байна. “Хүйс”-ийн бэлгэ тэмдэгт ихэнх соёлынхон “жинхэнэ эр хүн” бүтээх хэлбэр, механизмыг идэвхтэй судалж сэтгэл санаа, тэнгэрлэг чанар, идэвхтэй байдал, хүч чадал, гэрэл гэгээ,

* МУИС, Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим

ухаалаг зорилготой байх, эр зоригт хамаарах цэрэг, арми, биеийн тамир спорт, элдэв сорилт хамгийн чухал эр шинжид тооцогдож, “хатуу”, “бүргэд”, “шарх эр хүнийг чимдэг” зэрэг үг хэллэгийг “эрэгтэй” хэмээх ойлголтод, харин “эмэгтэй” хэмээх ойлголтод эмх цэгц муу, байгалийн төрхөөрөө, идэвхгүй, сул дорой, дотоод сэтгэл болон сэтгэл хөдлөлийн өөрчлөлтүүдээ тэр бүр ил гаргадаггүй, дотроо хадгалан үлддэг, сэтгэлийн уян, “ээлдэг зөөлөн”, “гургалдай” зэрэг шинж чанар илэрдгийг М.Фуко зэрэг судлаач онцолсон байдаг.

17-р зууны үед эмэгтэйчүүдийн хэл ярианы онцлог шинж болон үгийн сангийн ялгааны талаар, эрэгтэйчүүдийн хэл яриа нь хэвийн тул судлах шаардлагагүй, харин эмэгтэйчүүдийн хэл яриа “хэвийн бус” учир судлах хэрэгтэй гэсэн үзэл гарч байв. Р.Кэмбриж 1754 оны “The World” сонинд “эмэгтэйчүүдийн үгийн сан тогтвортой удаан оршин байдаггүй нь тэд ач холбогдолгүй юмны талаар ярилцдагтай нь холбоотой” гэж бичсэн байж билээ.

Европчууд анх Төв Америкийн Бага Антилын аралд хөл тавихад эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд өөр өөр хэлээр ярилцдаг болохыг ажиглан тэмдэглэн үлдээсэн байна. Эмэгтэйчүүдтэй харьцуулбал эрчүүд хоорондоо харилцахдаа үгийн онцлог үндэс, хэлзүйн дүрэм баримталдаг хийгээд найруулгын хэм хэмжээг хатуу баримталдаг байсныг тэмдэглэжээ. Аж төрөх ёс, сүсэг бишрэл, уламжлал зэргээс улбаатай тодорхой үг хэллэг, яриа зэргийг цээрлэх, эерүүлэн хэлэх ёс америк тивийн уугуул оршин суугчид, евроази, австрали тивийн хүмүүсийн дунд нийтлэг байсан аж. Жишээ нь: Зулуус омгийн гэрлэсэн эмэгтэй хадам, нөхрийн ах, дүү нарын нэрийг дуудах цээртэй бөгөөд тэдгээрийн нэрэнд ордог тодорхой авиан үе бүхий энгийн үгийг ч чанга хэлэх ёсгүй байж... Манай ойрад эмэгтэйчүүдийн хэл ярианд зарим үгийг өөр үгээр эерүүлэн нэрлэх ёсыг “*бэрлэх ёсон*” хэмээн нэрлэх бөгөөд, энэ нь гол төлөв хадам эцэг эх, ахмад настай хүний нэрийг цээрлэх, авгайлах уламжлалтай холбоотой аж. Төв халхад өнгөрсөн зуунд амьдарч байсан *Алаг* хатны нэрийг дуудахаас цээрлэн “*алаг*” гэсэн үгийг *шаазгай*, *цоохор* зэргээр эерүүлэн ярилцдаг байсан зэрэг ийм нийтлэг заншил их байгаа нь хэл яриа бол хүйсийн шинжээр ялгарах нэг хүчин зүйл болдог хэмээн үзэж болох юм. Ер нь хэл бол байгалийн ч бүтээгдэхүүн, нийгмийн ч бүтээгдэхүүн юм.

Феминистүүд хэл өөрөө байгалиас үүсээгүй харин нийгэм түүхийн үзэгдлийн явцад үүссэн бөгөөд байнга хувьсан өөрчлөгдөж, шүүмжлэгдэж байдаг нийгмийн үзэгдэл учраас эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хэлэнд гарч байгаа ижил биш байдал нь ч үүнтэй холбоотой гэж үздэг. Хувь хүний өөрийн нийгмийн ач холбогдлоо ухаарах ухаарал нь түүний хэл ярианы практикаар дамжин хэрэгжиж байдаг бөгөөд орчин үед феминизмийн ухамсарт эсэргүүцэл өөрийн илрэлээ хэлшинжлэлийн төвшинд ч олж эхлээд байна. Жишээ нь, урьд өмнө нь зөвхөн эр хүйсийг заадаг байсан нэр томьёонууд өнөөдөр эм хүйс дээр хэрэглэдэг болоод байна. Утгын акцентын өөрчлөлтүүд үгийн үеүдэд хүртэл тодорхой гарах болсон. Энэ өөрчлөлтийг гарах болсон үндсэн суурь нь 1960-аад оны сүүлч 1970-аад оны эхэн үед хэл шинжлэлд жендер хэмээх нэр томьёо орж ирж, түүх, социологи, сэтгэл судлалын шинжлэх ухаанд түлхүү хэрэглэх болсон нь хэлийг хүн төвтэй гэх үзэл төлөвшихөд ач холбогдлоо өгсөөр байна.

Жендерийн түүх (her story “эмэгтэйчүүдийн түүх”, his story “эрэгтэйчүүдийн түүх”) гэдэг нь эмэгтэй хүмүүсийн амьдралын туулж ирсэн зам, туршлагыг илтгэн үзүүлж байгаа юм. Энэ чиглэлийн анхны судалгаануудын нэг бол бидний дунд амьдарч байсан нэр нь тодроогүй алдартай эмэгтэйчүүдийг архивын мэдээ баримтаас олж илрүүлэхэд чиглэгдэж байсан. Ингэснээр эмэгтэйчүүдийн амьдралын туршлага, байгуулсан

гавьяанд тулгуурлан түүхийн шинжлэх ухааны шинэ категори жендерлогийг бий болгохыг шаардаж байна.

Судлаач Хэнли (4.825-836) англи хэлэнд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг янз бүрээр дүрслэн бичих маш өргөн боломж, цар хэмжээ байдаг болох дурдсан байдаг. Жишээ нь: Нөхөрт гарсан эмэгтэйг нэрлэх тусгай нэршил(missis) байдаг атал эхнэртэй эрд зориулсан үүнтэй адил нэр томьёо байхгүй байна. Энэ юун тухай өгүүлж байна вэ? Эрчүүдээс ялгаатай нь, эмэгтэй хүний гэр бүлийн байдал нь түүнийг бусад хүн хэрхэн хүлээн авч, түүнтэй ямар маягаар харьцах вэ гэдэгт нөлөөлнө гэсэн үг. Хэнли цааш нь “эмэгтэй хүнийг буруу талаас нь тодорхойлон хэлэхэд хэрэглэдэг үгнээс эрэгтэйгийнх 6-10 дахин олон болохыг илрүүлсэн байдаг. Эдгээр үгэнд бидний соёлд хэвшсэн, зохих жендерийн зан үйлийн талаарх мэдээлэл агуулагддаг” гэжээ.

Жендер нь бие даасан байдлыг илэрхийлэх нийгмийн нэг статус болдог учраас нийгмийн соёлын хүрээнд үйлчилж жендерийн соёлыг үүсгэдэг бөгөөд бусад салбар шинжлэх ухаан болох жендерийн хэл шинжлэл, жендерийн түүх, жендерийн сэтгэл судлал, жендерийн социологи гэх мэт салбар шинжлэх ухааныг үүсгэсэн байна.

Жендерийн хэл шинжлэл нь 1960-аад оны үед Америкийн Нэгдсэн Улсад бий болсон хэлийг шүүмжлэх феминист үзэлтэй холбоотой гарч ирсэн хүн төвт хэл шинжлэл (anthropological linguistic) юм. Хэлний тухай орчин үеийн онол болох “хэл бол хүн төвтэй” гэсэн үзэл нь В.Гумбольдтын “хэл бол соёлын толь бөгөөд хүний ертөнцийг үзэх зөн билгийн онолыг үгүйсгэн, хэл нь соёлын бүтээлийн нэг чухал хүчин зүйл юм” гэж тодорхойлсон. Өнөөдөр хэл нь ерөнхийдөө хэлэхүйн болон ахуйн талаасаа хүн төвтэй болох нь батлагдаад байна.

С.А.Ушакин үзэхдээ, манай улсын хэл шинжлэлд “жендер” нь өргөн хэрэглэгддэг ба ихэнх судлаачид “пол-хүйс” гэдэг нэр томьёотой адилтгаж болох юм шиг санадаг. Гэвч энэ үгийг “пол” гэдэг үгтэй адилтгаж болохгүй бөгөөд англи хэлний “секс” гэсэн ойлголтоос ч өөр юм. Түүний үзэж байгаагаар “жендер” гэдэг үгийг “нийгмийн хүйс” гэж хэлж болох юм.

Д.О.Добровольский, А.В.Кирилина нар жендерийн хэл шинжлэлийн хэтийн төлөв, чиг хандлагад онош зүйн шинж тэмдгийн судалгаа хийн, гэмт хэргийн бүрдүүлэлтийг бий болгох, нэр нь үл мэдэгдэх зохиогчийн хүйсийг тодруулж, шинж чанарын давтагдах байдалд анализ хийх, хүний үг яриа, дуу хоолой, хүйсийн ялгаатай байдал болон бусад шинж тэмдэг (нас, хүйс, нийгмийн харьяалал, хэл, соёл) зэргийг таньж оношлох үйл ажиллагаа явуулахыг зорьж байсан. (5)

Потапов, зөвхөн байгалийн хүйстэй холбоотойгоос гадна, хүн өөрийн хүйсийг өөрчилж эсрэг талын хүйсийнхээ зарим нэг шинжийг нь дуурайх байдал (тусгай аппарат, программын тусламжтай гэмт хэргийг илрүүлэхэд ашиглаж байгаа) дээр үндэслэн, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн гармоны тэнцвэрт байдал дээр ажиглалт хийн танин мэдэхүйн ялгааг нь тогтоох зорилгоор сэтгэл судлал болон нейро хэлшинжлэлийн хосолсон судалгаа хийжээ.

М.В.Ласкова Жендерийн судалгаанд хүйсийг дүрэм талаас нь задалж үзэх анхны оролдлого хийсэн. Жишээ нь: Энэтхэг-Европийн олон хэлэнд хүйс нь чухал ай болдог бөгөөд ялангуяа орос хэлэнд нэр үгийн бүх аймаг, үйл үгтэй зохицох хамгийн чухал ай болдог. Хэрэв ямар нэг хэлэнд хүйсийн ай байвал тэр хэлэнд ганц ба олон тооны ай байх нь гарцаагүй. Өөр нэг нийтлэг зүйл бол хэлэнд ганц тоонд байх хүйсийн ай нь олон тооныхоос үргэлж давамгайлж байдаг.

1980 онд И.Гюнтеродт, М.Хеллингер, Л.Пуш, С.Тремель-Плетц нарын бүтээлээс санаа авч “Хэлэнд хүйсээр гадуурхах явдлаас зайлсхийх оролдлого” (3.11) гэсэн ном хэвлүүлсэн. Түүнд өгүүлэхдээ Герман хэлэнд эмэгтэй хүнийг эрэгтэй хүнтэй харьцуулсан харьцуулалт нь магтаал сайшаал шиг сонсогдож байна. Жишээ нь: Sie steht ihnen Mann “Тэр өөрийн хийх зүйлээ сайн хийдэг”. Харин эрэгтэйчүүдийг эмэгтэйчүүдтэй харьцуулахдаа доромжлон дорд үзэж буй мэт. Er heult wie ein Weib. “Тэр хүүхэн шиг хашгирч байна” гэсэн байна. Герман хэлний өвөрмөц хэллэгт эмэгтэй хүнийг хоёрдугаар зэрэгт тавьсан үг хэллэг зонхилдог юм байна.

Судлаач Маршал, Рибери нар эмэгтэй хүний “төрөлхийн дорд” шинж болоод эрэгтэй хүний хуурмаг давуу тал хоёрын хоорондын бодит зөрчилдөөн дээр үндэслэсэн далд нуугдмал “секс” үг яриаг дээрх маягаар нээн илрүүлсэн байна. Жишээ нь: “Пти Ларусс” хэмээх нэвтэрхий толинд, эрдэмтэн Мари Склодовская-Кюри(1903, 1911 оны Нобелийн шагналт)-гийн талаар бичсэн байна. Тэнд “Кюри Пьер-францын физикч. Тэрээр физик дэх симметрийг (тэгш хэмт байдлыг) судалж, цахилгаан гүйдлийн даралтыг нээсэн. Кюри Пьер өөрийн эхнэр Мари Склодовскаягийн хамтаар судалгаа хийж, ради-(цацрагийн энерги дамжуулдаг төмөрлөг)-ийг нээжээ” хэмээн бичсэн байдаг. Энэ өгүүлбэрүүдэд эмэгтэй хүйсийн бие даасан, хараат бус байдлыг орхигдуулж, үгүйсгэсэн байгаа нь илт ажиглагдаж байна. *Нэгдүгээрт*, нэвтэрхий тольд Мари Склодовская-Кюрид өөрт нь зориулсан гарчиг огт байхгүй, харин түүнийг Пьер Кюригийн эхнэр болохынх нь хувьд дурджээ. Гэтэл тэр эмэгтэй өөрөө бас бие даасан эрдэмтэн байсан байна. *Хоёрдугаарт*, М. Кюри өгүүлбэр зүйн гол субъект болж нэг ч удаа дурдагдсангүй. *Гуравдугаарт*, М.Кюригийн эрдэмтний хувиар гүйцэтгэсэн үүргийг нь үгүйсгэснээрээ, хоёр шагналыг хоёуланг нь Пьер Кюри хүртсэн мэтээр ойлгоход хүрч байна. Гэтэл эхний шагналыг тэр хоёрт хамтад нь өгсөн бөгөөд харин хоёр дахь шагналыг ганцхан Марид олгосон юм. Энэ үед Пьер Кюри нас нөгчөөд таван жил болсон байлаа.

Пьер Кластр, Хэл яриа бол зөвхөн харилцааны хэрэгсэл төдий зүйл бус, тэрээр хувь хүмүүсийг тодорхойлдог гэж бичээд: Өмнөд Америкийн Гуайка омгийн “эр хүн” гэсэн ойлголтыг задлан тодорхойлж амьд буюу хүнд хамааралтай хэлшинжлэлийн нэр томъёогоор тодорхойлж чадсан бол, харин эмэгтэй хүнийг тодорхойлоход амьгүй зүйлс шиг буюу, хэн нэгний өмч мэт илэрхийлэл маш олноор хэрэглэжээ. Тухайлбал, “өөрийн эмэгтэйтэйгээ гэрлэх”, “өөрийн эмэгтэйтэйг ээлжлэх”, “өөрийн эмэгтэйтэйг өгөх”, “өөрийн эмэгтэйтэйг санал болгох” гэх мэт яг л хувийн өмчдөө хандаж буй мэт хандлага илт ажиглагдахаар хэллэгүүд орсон байна. Тэрчлэн тухайн эмэгтэй хүнийг дуудаж буй олон тооны нэршил байна. Зарим тохиолдолд эмэгтэйд нь хамаатуулсан эр хүний ч нэршил болох “авдаг эмэгтэй”, “өгдөг эмэгтэй”, “ойртдог эмэгтэй”, “хэн нэгний эмэгтэй”, “эмэгтэйтэй өмчлөгч” гэх мэт. Энэхүү харанхуй бүдүүлэг гэж нэрлэгддэг нийгэмд эмэгтэй хүний эзлэх байр суурь нь тодорхой нэг хэвшил ба ёс заншлаас үүдэн бүрэлдсэн хувийн өмчийн адил ханддаг болжээ.

Гэтэл орчин үеийн соёлт нийгэмд эр эм хоёрыг гэр бүл болоход эмэгтэй нь нөхрийнхөө нэрийг авдаг ёс байсаар байна. Харин нөхөр нь эхнэрийнхээ нэрийг авах тийм ёс байдаггүй байна.

Тэрчлэн эрэгтэй хүний тухай ярихад түүний мэргэжлийн болон бусад чанаруудыг тоочин ярьдаг бол, харин эмэгтэй хүний талаарх яриа өрнөх тохиолдолд түүнийг эмэгтэй гэдэг талаас нь л ярьдаг болохоос бусад чанаруудынх нь талаар төдийлөн дурддаггүй байна.

1999 оны 11-р сард Москва хотноо жендерийн хэлшинжлэлийн олон улсын анхны бага хурал “Жендер, хэл, соёл, харилцаа” нэртэйгээр хуралдсан байна. 2000 онд “Хэл бичгийн ухаан” сэтгүүлийн 3-рт бүхэлдээ жендерийн тухай өгүүлүүд хэвлэгдсэн байна. Энэ өгүүллийн ихэнх нь жендерийн хэлшинжлэл уран зохиолтой холбоотойгоор авч үзсэн бөгөөд жендер нь дотоод хүмүүжлийн шинж чанарыг өөртөө агуулдаг, уншигчдын сонирхлыг илэрхийлдэг болохыг ихэвчлэн дурдсан байна.

XX зууны эхэнд О.Есперсений бүтээлд “Хэл ба хүйс” гэдэг нэр томьёо гарч ирсэн бөгөөд, “Хэл, түүний чанар, гарал, үүсэл, хөгжил” номдоо эрэгтэй эмэгтэй хүний хэлний тухай нэг бүлэг болгон бичсэн байна.

Тэрчлэн Энэтхэгийн зарим овгуудад эрэгтэй, эмэгтэй хүний хэл яриандаа хэрэглэх дагавар өөр өөр байсан байна.

Зарим овог аймагт эмэгтэйчүүдийг эрэгтэй хүнтэй ямар нэг хэмжээгээр холбоотой үг хэллэг хэрэглэхийг хүртэл хориглон, хэрэв хэлэх хэрэгтэй тохиолдолд шууд бус байдлаар, утгачлан хэлэх ёстой гэж үздэг байсан байна. О.Есперсений ажигласнаар эмэгтэй хүн зөвхөн төрөлх хэлтэйгээ үлддэг байхад харин эрэгтэй хүн гадаад хэлийг түргэн хугацаанд эзэмших явдал их байсан байна. Иймээс эмэгтэй хүн хэлний их авьяастай боловч хэлний хэрэглээнд хуучинсгаар ханддаг гэж тогтоосон байна.

Эмэгтэйчүүдийн ярианд паратаксист-гишүүд нь дутуу өгүүлбэрийг их хэрэглэдэг байхад, эрчүүдийн ярианаас гипотаксист-таамаглал давамгайлах чиглэл ажиглагддаг. Энэ үндсэн дээр О.Есперсен, эрэгтэй хүн бол эмэгтэй хүнээс оюун ухааны хувьд давуу талтай юм гэсэн дүгнэлт гаргасан. Эрэгтэйчүүд өөрийгөө өргөх маягийн үг хэллэг, хошин шог, тоглоом хийсэн маягийн бүдүүлэг үг хэллэг их хэрэглэдэг юм байна.

Хэлний феминист шүүмжлэлийн хүрээнд Р.Лакоффийн бүтээл суурь болж гарч ирсэн. Тэрээр хэлний эр хүн төвт үзэл давамгайлах шинжээс үүссэн эмэгтэй хүний дорой байдал, дүр зургийг өөрийн бүтээлд гаргасан (7). Энэ бүтээлд эмэгтэйчүүдийг ямагт хоёр дахь ч үүргийг гүйцэтгэдэг (ихэвчлэн дүрмийн хувьд эр хүйс нь өөртөө агуулах механизм дээр тулгуурладаг, учитель-эрэгтэй хүнийг заах ба эмэгтэй хүнийг ч зааж болно) гэсэн үзэл дээр тулгуурлан хэлний системийн “ассиметр- тэгш бус байдал” гэдэг ойлголтын тухай авч үзсэн. Энэ үзэл христ болон мусалман шашинтай орнуудын хувьд илүү их ажиглагдсан. Харин өөр бусад хэлэнд шашин соёлоосоо хамаараад янз бүр байсан (2.5) гэжээ.

Судлаачид эрэгтэй эмэгтэй хүмүүсийн зан байдал, хэл ярианы онцлогийг эрэгтэй эмэгтэй хүмүүсийн харилцааны шинж тэмдгийн тогтмол чанар дээр үндэслэсэн “гендеролект-хүйсийн аялгуу” гэсэн ойлголтыг гаргаж ирсэн.

Ингэхдээ эмэгтэй хүний хэлэхүйн зан үйлийг илтгэсэн дараах шинж чанаруудыг гаргажээ. Үүнд:

1. Хөндлөнгийн юмын дамжуулахдаа хэвшсэн маягтай, ихэнхдээ аргадсан, зөөллөсөн шинж чанартай,

2. Хэлэхүйн үйлдэлд голлох байр суурь эзэлдэггүй боловч сайн сонсогч байж чаддаг,

3. Эмэгтэй хүний хүмүүнлэг шинж чанар нь хэлэхүйн зарим тохиолдолд төвөг учруулах, бас эсрэгээр нөлөөлдөг,

4. Эмэгтэй хүний хэлэхүйн үйлдэл тогтсон нэг хэвийн, хорших шинжтэй, эрэгтэй хүнтэй хараалын, бүдүүлэг үг хэллэг бага хэрэглэдэг, өөртөө итгэлгүй байх зэрэг нь тухайн нөхцөл байдлыг ойлгоход хүндрэлтэй, итгэх аргагүйд хүргэдэг.

5. Эмэгтэй хүн захиран тушаасан маягийн үг хэллэг хэрэглэж эхэлбэл давшсан дайрсан шинж нь давамгайлж харилцааны утга алдагдах, үнэлэмж нь багасах, улмаар түрэмгийлсэн, утгагүй харилцаа болдог. Ийм учраас эмэгтэй хүнийг сонсогч байхад туслах тусгай арга зүйг боловсруулах нь зүйтэй гэсэн бодлого гарч ирсэн байна.

Нийгмийн хэл шинжлэлд “гендеролект” хүйсийн тухай ойлголт нь мэргэжил, нас, нийгмийн гарал үүслийн адил нийгмийн шинж тэмдгийн нэг болдог.

1990-ээд оны үеийн нийгмийн хэл шинжлэлийн чиглэлээр гарсан бүтээл туурвилуудад эмэгтэй хүний хэлний хэв шинж, сонирхол, төрөлхийн шинж чанартай холбоотой судалгаа нэлээд гарч, голлон хэрэглэдэг үг бүхий толь бичиг ч гарсан. Эмэгтэй хүн үргэлж нялуун, хачирласан үг хэллэг хэрэглэдэг, яагаад гэвэл, тэд хэн нэгний сэтгэлийг гонсойлгохоос айдаг. Иймээс тэд яриандаа “миний бодлоор”, “чи мэдэж байгаа шүү дээ” гэх мэт үг хэллэг, тэрчлэн “магадгүй”, “тийм үү, үгүй юу” гэх мэт асуух өгүүлбэр хэрэглэдэг бөгөөд эрэгтэйчүүдийн хэлдгээр тэд бол хэтэрхий эелдэг, тэр бүү хэл, яриандаа хошигнол, хараал хэрэглэх нь бараг ажиглагддаггүй юм байна.

Е.А.Земская “эмэгтэй хүний хэл яриа бол уян хатан чанартай бөгөөд харилцах нөхцөлөөсөө шалтгаалж өөрийн үүргийг хялбархан өөрчилж чаддаг, эрчүүд бол сэтгэл зүйн хувьд дүлий тул хариултанд анхаардаггүй”(6) гэж үзсэн байна. Эмэгтэй хүний хэлэхүйн үйлдэл энэрэнгүй, хүмүүнлэг шинж аястай байдаг учраас тэдний ярианд байгаль орчин, амьтан, өдөр бүрийн амьдралын тухай яриа зонхилдог бол эрэгтэй хүний ярианд спорт, ан агнуур, дайн байлдаан, улс төрийн сэдвүүд голлох хандлагатай байдаг.

Биеийг хүйсээр нь ангилсан нэр үг бүхий хэлний материалд (гражданин-иргэн эрэгтэй, гражданка-иргэн эмэгтэй) дээрх санааг батлан харуулж байгаа бөгөөд эр хүйсийн үг нь анхдагч утгыг илэрхийлж байна.

Хэл нь хүний туршлагын бэлгэ тэмдгийн тогтолцоо, бүрэн гүйцэт эзэмшээгүй мэдлэгийн сан болдог ба хүний бодит байдалд хандах харилцаа хамаарлыг өөрийн нэгжээр гаргаж өгдөг.

Хэл шинжлэлийн судалгаа жендерийн судалгаагаар дамжуулан нийгэмшлийн явц дахь соёлын болон нийгмийн томьёолбор гэж нэрлэгдэх хэлний үнэ цэнэ, тогтолцоо, хэм хэмжээг задлан шинжилж болно.

Эмэгтэйчүүдийн хэлэхүйн онцлогийн талаар судлаачид өөр өөрийн үзэл бодлоо илэрхийлэхдээ гол төлөв авиалбар, хэл зүй, үгийн сан, найруулгын талаар нэлээд бичсэн байдаг юм.

Судлаач Р. Лакофф “хэл ба эмэгтэйчүүдийн байр суурь” бүтээл хэвлүүлж түүндээ эмэгтэйчүүдийн үгийн сан, хэлэхүйн ялгааны талаар дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг. Тэрбээр, эмэгтэйчүүдийн хэл яриа нь эрэгтэйчүүдийнхээс,

а. Эрэгтэйчүүд огт хэрэглэдэггүй (*mauve* – хөх ягаан ...г.м.) үг яриандаа хэрэглэдэг,

б “sweet, diving, cute” зэрэг хийсвэр утгатай тэмдэг нэр түлхүү хэрэглэдэг,

в. Эрчүүдийн хэл яриандаа батлах хэлбэр хэрэглэдэг газар гол төлөв асуух хэлбэрийг (*tag questions*) ашигладаг,

г. Хэл яриандаа гол төлөв эелдэг байдлыг үзүүлдэг,

д. Мөн “well, you know, guess, I wonder, I thin” зэрэг эргэлзсэн, итгэлгүй баймж утгат үг хэллэгийг их хэрэглэдэг,

е. “Хэлзүйн дүрмийг нягт баримталдаг”-аараа ялгардаг,

ё. “Сэтгэл татам, гайхамшигтай, хонгорхон” зэрэг үгийг голцуу эмэгтэйчүүд илүү хэрэглэдэг болохыг онцолжээ.

О.Есперсеней “Хэл” (Language, 1922) хэмээх бүтээлдээ эмэгтэйчүүдийн хэл ярианы онцлог шинжийн талаар олон жишээ баримт дурдсан байна. Жишээ нь: “Эмэгтэйчүүдийн үгийн сан эрчүүдтэй харьцуулбал арай ядмаг. Тэрбээр, “pretty”, “nice” зэрэг хавсрал нэр үгийг эмэгтэйчүүд түлхүү хэрэглэхийн зэрэгцээ, “vastly” хэмээх дайвар үгийн хэрэглээний талаар тусгайлан ажиглаж “эмэгтэйчүүд аливаа зүйлийг илүү дөвийлгөн ярьдагтай уялдан уг дайвар үгийн анхдагч, цөм утгыг нь үл анзааран хаа сайгүй хэрэглэдэг” гэж дүгнэсэн байдаг. Мөн “so” хэмээх дайвар үгийг “It is so lovely. He is so charming. Thank you so much, I’m so glad you’ve come” зэрэг олон тохиолдолд эмэгтэйчүүд хэрэглэдэг нь хүйсийн онцлог юм. “Эмэгтэйчүүд өөрсдөө анхандаа юу хэлэхээр завдаж байгаагаа умартан, хэлэх өгүүлбэрээ илүү их тасалдаг” гэж дүгнэсэн.

Тэрээр “эмэгтэйчүүд бус харин эрчүүд үг хэллэгийг үгийн санд оруулж байдаг, иймд тэд (эрчүүд) хэл яриаг бий болгон бүтээгчид юм” гэжээ.

Судлаач О.Эткинс, Бард нар эмэгтэй, эрэгтэй хүмүүс шүүх хуралд мэдүүлэг хэрхэн өгч байгааг судлан улмаар, гэрийн эзэгтэй нар болон галч, жижүүр, үйлчлэгч нарын хэл яриаг “powerless language” буюу “нийгмийн доогуур хэсгийн хэл яриа” гэсэн нэр томъёо хэрэглэсэн байна.

В.Вулф “A room of one’s own” (1922) бүтээлдээ “эрэгтэй хүний бичсэн зүйлийг уншихад эмэгтэйчүүдтэй харьцуулбал хэлзүйн хувьд илүү зөв хэлбэртэй, хэм хэмжээ баримталсан байдаг” хэмээжээ.

Хэлэнд хүйсийн ялгаа ажиглагдах талаар 1946 онд судлаач Фланнери “Men’s & Woman’s speech in Gros Ventre” өгүүлэлдээ, Монтана хавьд оршин суугч Грос вендр (Gros Ventre) омгийнхон [к] тэсэрдэг гийгүүлэгчийг эрчүүд өөр гийгүүлэгчээр сольж хэрэглэдэг талаар дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг. Жишээ нь: “Шинээр төрсөн хүүхэд” гэвэл эмэгтэйчүүд [waKinsihqa], эрчүүд [wadinsihqa] гэж дууддаг бол, [талх]-ийг эмэгтэйчүүд [Kiatsa], эрчүүд [dzatsa] хэмээн дууддаг нь хүйсийн хамааралтай холбоотой юм. Энэ омгийн хэлний бүлэгт авианы дуудлага нь хүйсийг тодорхойлогчийн үүрэг гүйцэтгэгч болдог бөгөөд хэн нэг нь буруу дуудсан тохиолдолд түүнийн хос хүйстэй гэж тооцон үзнэ хэмээн ахмад хүмүүс зэмлэдэг тухай бичсэн байна. Мөн Сибирь хавиар оршин суугчдын Чукот хэлэнд яригчид хүйсээс хамаарч [s] авиаг эмэгтэйчүүд, [ts], [r] авиаг эрчүүд ихэвчлэн яриандаа хэрэглэдэг талаар дурджээ. Жишээ нь [Samkissin] гэж эмэгтэйчүүд хэлэлцдэг бол [Ramkissin] зэргээр эрчүүд хэлэлцдэг онцлогтой байна.

Хэл шинжлэлч Э.Сепир “Эмэгтэйчүүдийн ярианд илрэх хураангуйлсан хэлбэр нь тэдний нийгэмд эзлэх байр суурь доогуур байгааг илтгэдэг бол эрчүүдийн хэл ярианд илрэх хэлзүйн бүтэн хэлбэр нь албан ёсны хэвт байдлыг илэрхийлдэг” хэмээн дүгнэж, эрчүүдийн хэл ярианы энэ шинжийг хэлний түүхэн уламжлал, хэлний цэвэр байдлыг хадгалдагтай холбон тайлбарлажээ. Үүнийгээ, олон хэлний нийтлэг үзэгдэл болох бүтээвэр, авиалбар хэмнэн хэрэглэх зарчим юм. Жишээ нь: omnibus - bus, refrigerator - fridge ... г.м.

Мөн АНУ-ын Калифорни мужийн уугуул иргэдийн Яна хэлэнд эмэгтэйчүүд-эрчүүд, эрчүүд-эрчүүд, эмэгтэйчүүд-эмэгтэйчүүд хоорондоо ярилцах хэл яриа нь өөр өөр байдаг талаар бичсэн нь буй.

Нэрт монголч эрдэмтэн Я.Г. Рамстедт халимаг бүсгүйчүүдийн хэлэлцдэг үг, хэлний хэлбэрээс зүйл зүйлийн сонин содон хэрэглэгдэхүүнийг халимаг хэлний толь бичигтээ оруулжээ. Үүнд: Халимаг бүсгүйчүүд наад зах нь гурван зүйлийн арга хэрэглэж өөрийн

хэл яриагаа бусдаас онцлог ялгаатайгаар хэрхэн илэрхийлдгийг мэдэж болно. Жишээ нь:

Нэгдүгээрт, олны хэлдгээс өөрөөр нэрлэх ёстой ухагдахууныг утга ойролцоо үгээр нэвтрүүлдэг.

Хоёрдугаарт, утга адил санаа давтах өөр үг эс олбол, нийтэд хэрэглэгддэг утга нь илэрхий үгийн дуудлагыг нэгэн онцгой маягаар хувирган, голдуу үгийн эхний гийгүүлэгчийг [j]-аар сольж дууддаг байна. Авианы түүх судлалаас үндэслэн нийтээр хэлэлцдэг үгийг бүсгүйчүүд хувиргаж хэлэхдээ үгийн эхний гийгүүлэгчийг [j] гийгүүлэгчээр сольж хэлэлцдэгийн учрыг бусад харийн хэлний ёсонд үгийн эхний гийгүүлэгчийг мөнхүү [j]-ээр сольж хэрэглэж үүссэн хэмээн таамаг гаргасан.

Бас эгшиг сэлгэж хэрэглэснээр үгийн дуудлагыг өөрчлөн хэлэлцдэг ёсыг, хэлний урдуурх (эм) эгшгийг хэлний хойгуурх (эр) эгшиг болгон дуудахдаа, урдуурх гийгүүлэгчийг хэвээр нь дууддаг гэсэн.

Гуравдугаарт, ёгт үг хэрэглэн эерүүлэн нэрлэх ёсон байна. Үүнд, ах хүний нэр, ялангуяа төрөл садан эмэгтэйчүүдийн нэрийг цээрлэн эерүүлэн дууддаг ажээ. Тэдгээр нэрийн зүйлийг хүн авгайлан дуудахад хэрэглэх, юмны байдлыг “ийм, тийм” гэж заан хэлэх үгэнд оруулахдаа эерүүлэн нэрлэдэг байна. Ингэж эмэгтэйчүүдийн нэр цээрлэн хэлэлцэх ёсыг халимгаар [berlxe, bermsixe] хэмээн нэрлэдэг.

Орчин үеийн нийгмийн хэлшинжлэлийн ухаанд жендерийн хэл шинжлэл нь бие даасан салбар шинжлэх ухаан гэж үздэг. Үнэхээрч нийгмийн хэл шинжлэлийн хүрээнд үүсэн буй болсон жендерийн хүчин зүйлийг сонирхон судлах нь нэмэгдсээр байна. Үгийн сангийн бие даасан нэгж болох жендер нь хүний зан байдал, соёл, сэтгэл зүйн онцлогийг илэрхийлсэн, хэлэнд янз бүрийн хэм хэмжээний загварыг гаргаж ирдэг ойлголт юм. Иймээс эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш бус байдал, тэдний харьцаа нь хэлэнд шатлан захирах ёсны шинжээр ижилссэн боловч бие биенээсээ эсрэг тэсрэг шинж чанар агуулж байдаг талаар, тухайлбал нийгмийн хүйсийн талаар судлах зүйл их буй тул нэн сонирхолтой болой.

НОМЗҮЙ

1. Коллинс (1999), Большой толковый социологический словарь. М, АСТ. 189 ст.
2. Кирилина. А. В. (2000), О применении приятия “гендер” в русскоязычном лингвистическом описании. Москва.
3. Ласкова. М. В. (2000) Грамматическая категория рода в аспекте гендерной лингвистики. Москва.
4. Henry David B., schoeny Michael E., deptula Daneen P., and slavick John T (2007), “Peer Selection and Socialization Effects on Adolescent Intercourse Without a Condom and Attitudes About the Costs of Sex”, Child Development, 78(3), 825 – 838.
5. Добровольский.Д.О, Кирилина.А.В (2000), Феминистская идеология в гендерных исследованиях и критерии научности. Москва.
6. Земская.Е.А. Китайгородская.М.А. Розанова.Н.Н (1993), Особенности мужской и женской речи. Москва.
7. Lakoff, g. (2004), Women, men and language: a sociolinguistic account of gender differences in language. Longman.

РЕЗЮМЕ

Статья была написана автором с той точки зрения, чтобы внести свой скромный вклад в развитие и распространение совсем новой отрасли языкознания жендера, которая нуждается в уделении соответствующего внимания исследователей-лингвистов Монголии.

Кстати, автор надеется на то, что имеется богатый материал в сфере Монголоведения, связанный с условием и обстоятельством культуры мужских и женских полов.